

Шүгэл үлээх бодлого

Энэхүү бодлогоор “шүгэл үлээх” /цаашид мэдээлэх гэх/, мэдээллийг хүлээн авах, шийдвэрлэхтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулна. Энэхүү бодлогын зорилго нь асуудлыг тогтоох, түүнийг ямар нэг болгоомжлол, айх эмээх зүйлгүйгээр мэдээлэх, цаг хугацаанд нь шийдвэрлэх, мэдээлэл болон мэдээлэл гаргасан ажилтан эсвэл банктай гэрээний үндсэн дээр хамтран ажиллаж байгаа этгээдийн нууцыг хадгалахад оршино.

Энэхүү бодлогын дагуу дараах үйлдлийн талаар мэдээлнэ. Үүнд:

- Монгол Улсын хууль тогтоомжийг зөрчсөн байж болзошгүй үйлдэл;
- Банкны дотоод дүрэм, журам, тушаал, шийдвэр, ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн болон дараах үйлдлүүд:
 - Банкны өмч, мөнгө, хөрөнгө, нэр хүндэд хохирол учруулж болзошгүй итгэл алдсан үйлдэл
 - Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, нийгмийн болон гэрлэлтийн байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхсан үйлдэл;
 - Ашиг сонирхлын зөрчлөө толилуулаагүй үйлдэл;
 - Албан тушаалын эрх мэдлээ ашиглан ажилтанд аливаа хэлбэрээр дарамт, шахалт үзүүлсэн үйлдэл;
 - Бэлгийн болон сэтгэл санааны дарамт, шахалт үзүүлж буй үйлдэл;
 - Ажил мэргэжил, албан тушаалдаа хайнга хандсан, алдаа гаргасан үйлдэл;
 - Аливаа хууль бус, зүй бус зүйлийг нуун дарагдуулж буй үйлдэл;
 - Бусад эрсдэлтэй гэж үзсэн үйлдэл, эс үйлдэл.

Шүгэл үлээгч нь мэдээллээ Банкны дотоод тусгай зориулалтын мэдээлэх цахим шуудангийн хаягаар (shugel@хасbank.mn) эсхүл өөрийн биеэр ирж, банкны Хянан нийцүүлэх асуудал хариуцсан мэргэжилтэнд гаргана. Шүгэл үлээгч асуудлын талаар өөрийн хэмжээнд баталгаа, нотолгоо гаргаж өгнө.

Шүгэл үлээгч нь мэдээлэл ирүүлэхдээ өөрийн хувийн мэдээлэл болон эргэн холбох мэдээлэл үлдээлгүй бүрэн нууцлалтайгаар ирүүлж болно.

Энэхүү бодлогын дагуу үнэнч шударга сэтгэлээс мэдээлэл гаргасан ажилтанг хохирогч болгохгүй талаар мэдээллийг хүлээн авсан болон мэдээллийн мөрөөр шалгалт хийсэн ажилтнууд анхаарч ажиллана.

Мэдээллийг хүлээн авсан болон мэдээллийн мөрөөр шалгалт хийсэн ажилтнууд мэдээллийн нууцлалыг хадгалах, мэдээлэл гаргасан ажилтны нууцыг хамгаалах үүрэгтэй.

Мэдээлэлд дурдсан асуудал нь шалгалтаар нотлогдоогүй ч мэдээлэл гаргасан ажилтанд хариуцлага хүлээлгэхгүй.

Мэдээлэл болон мэдээлэл өгсөн ажилтны нууцыг задруулсан ажилтанд банкны Хөдөлмөрийн дотоод журмын дагуу сахилгын шийтгэл ногдуулна.